



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2021 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 357

Улаанбаатар хот

**Үл хөдлөх хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох
тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4, 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцаас 2020 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтад оруулсан нийт 5 нэрийн 5,520,964,146.00 (таван тэрбум таван зуун хорин сая есөн зуун жаран дөрвөн мянга нэг зуун дөчин зургаан) төгрөгийн үнэ бүхий барилгыг нэгдүгээр хавсралтад заасны дагуу холбогдох аймаг, нийслэлийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Гадаадын буцалтгүй тусламжаар бий болж 2020 онд ашиглалтад орсон нийт 7 нэрийн нийт 88,483,568,516.32 (наян найман тэрбум дөрвөн зуун наян гурван сая таван зуун жаран найман мянга таван зуун арван зургаан төгрөг гучин хоёр мөнгө) төгрөгийн үнэ бүхий барилгыг хоёрдугаар хавсралтад заасны дагуу холбогдох аймаг, нийслэлийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

3. Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Батбаатар, Нийслэлийн өмчийн ашиглалт удирдлагын газрын дарга М.Баяраа, Архангай, Баян-Өлгий, Хөвсгөл, Дорноговь, Ховд, аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1. Улсын төсвийн болон гадаадын буцалтгүй тусламжийн хөрөнгө оруулалтаар нийслэл, аймагт бий болсон үл хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан, эзэмшигч байгууллагыг тогтоох, бүртгэлд тусгуулах асуудлыг шийдвэрлүүлэх;

3.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

3.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.4. Үл хөдлөх хөрөнгийн доорх газрын эзэмших эрхийг холбогдох төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн нэр дээр баталгаажуулах ажлыг зохион байгуулах;


132007783

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны .07. дүгээр сарын .22.-ны өдрийн
35.7. дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

**УЛСЫН ТӨСВИЙН САНҮҮЖИЛТЭЭР БИЙ БОЛСОН ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ
ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/Д	Төсөл арга хэмжээний нэр	Дүн (төгрөг)	Улсын комиссын актын дугаар	Бүртгэж авах аймаг, нийслэлийн хуулийн этгээдийн нэр
1	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 150 ор /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, 9 дүгээр цэцэрлэг/	1,366,241,813.00	БА-117/2020	Улаанбаатар хот, НӨУАГ
2	Дотуур байрны барилга, 100 ор /Хөвсгөл, Цагаан-Үүр сум/	1,562,628,615.00	УКД2020/101	Хөвсгөл аймаг, ОНӨГ
3	Сургуулийн дотуур байрын барилга, 30 ор /Баян-Өлгий, Булган сум/	83,802,902.00	№35/2020	Баян-Өлгий аймаг, ОНӨГ
4	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Ховд, Манхан сум/	128,500,000.00	А/19/2020	Ховд аймаг, ОНӨГ
5	Сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга худалдан авах /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 9 дүгээр хороо/	2,379,790,816.00	2020/221	Улаанбаатар хот, НӨУАГ
НИЙТ ДҮН		5,520,964,146.00		
		(таван тэрбум таван зуун хорин сая есөн зуун жаран дөрвөн мянга нэг зуун дөчин зургаа)		

---oOo---

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын г
2021 оны дүгээр сарын 28-ны өд
39... дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

**ГАДААДЫН БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖААР БИЙ БОЛСОН ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ
ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/Д	Төсөл арга хэмжээний нэр	Дүн (төгрөг)	Улсын комиссын актын дугаар	Бүртгэж авах аймаг, нийслэлийн хуулийн этгээдийн нэр
1	Сургуулийн барилга /УБ, Хан-Уул дүүрэг, 2-р хороо, 960 суудал, 75-р сургууль буулгаж барих/	21,496,473,590.00	№БА-053/2021	Улаанбаатар хот, НӨУАГ
2	Сургуулийн барилга /УБ, Чингэлтэй дүүрэг, 7-р хороо, 760 суудал, 149-р сургууль шинээр барих/	17,290,564,868.00	№БА-039/2020	Улаанбаатар хот, НӨУАГ
3	Сургуулийн барилга /УБ, Баянзүрх дүүрэг, 16-р хороо, 480 суудал, 53-р сургуулийн өргөтгөл/	11,385,476,100.00	№БА-038/2020	Улаанбаатар хот, НӨУАГ
4	Сургуулийн барилга /УБ, Налайх дүүрэг, 3-р хороо, 320 суудал, 109-р сургуулийн өргөтгөл/	9,016,458,081.00	№БА-057/2020	Улаанбаатар хот, НӨУАГ
5	640 хүүхдийн сургуулийн барилга, Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 25-р хороо	12,665,995,388.68	№БА-85/2020	Улаанбаатар хот, НӨУАГ
6	960 хүүхдийн сургуулийн барилга, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 12-р хороо	12,073,202,916.52	№2020/214	Улаанбаатар хот, НӨУАГ
7	100 ортой цэцэрлэгийн барилга, Архангай аймаг, Эрдэнэбулган сум	4,555,397,572.12	ББАОКД 2020/11	Архангай аймаг, ОНӨГ
НИЙТ ДҮН		88,483,568,516.32		
		(наян найман тэрбум дөрвөн зуун наян гурван сая таван зуун жаран найман мянга таван зуун арван зургаан төгрөг гучин хоёр мөнгө)		